



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

XVIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Зохион байгуулалт: Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 16.30 цагт Төрийн ордноос цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам”-ын төслийн танилцуулга

*Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга,
дэд хурандаа Т.Баярхүү,*

2. “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын нэмэлт өөрчлөлт

*Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга,
Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг,*

3. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Б.Ганзориг

4. Бусад

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН 18 ДУГААР ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран нарт:

1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах өдөр Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилсан сэргийлэх зорилгоор сонгогчдын санал авах байранд халдваргүйжүүлэлт хийх, сонгогчид, сонгуулийн байгууллагын болон мэргэжлийн байгууллагын ажилтныг хамгаалах хэрэгслээр хангах, бусад шаардагдах зардлын асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Зам тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга, Шуурхай штабын дарга Ц.Ганзориг нарт:

2.1. Улсын онцгой комиссын даргын 42 дугаар тушаалаар баталсан "Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж, журмыг хэрэгжүүлэх зохион байгуулалт, бэлтгэл ажлыг ханган иргэдийн зорчих хөдөлгөөнийг 2021 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн нээж, хяналт тавьж ажиллах;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Өмнөговь, Дорноговь аймгийн Засаг дарга нарт:

3.1. Өмнөговь болон Дорноговь аймаг руу зорчих иргэдийн хөдөлгөөнд 2021 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 6 сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хязгаарлалт тогтоож, зөвхөн уул уурхай, зам, барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалт, төрийн байгууллагын албан томилолтоор зорчих иргэдийн зөвшөөрлийг Улсын онцгой комиссын Шуурхай штабаас, хүндэтгэн үзэх шалтгаан (эмнэлгийн тусламж, үйлчилгээ, буяны ажил)-тай, харьяаллын болон байнгын оршин суудаг хаягтаа ирэх, буцах иргэд, зайлшгүй шаардлагатай ачаа тээвэрлэгчид (хүнс, шатахуун, эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа, материал, өвс, малын тэжээл)-ийн зорчих зөвшөөрлийг Өмнөговь болон Дорноговь аймгийн Онцгой комиссоос олгох;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Л.Баттөр нарт:

4.1. Улсын хэмжээнд иргэдийг дархлаажуулах ажлыг эрчимжүүлэх. Вакцины тээвэрлэлт, хадгалалтын горимд хяналт тавих. Улсын онцгой комиссын даргын тушаалаар орон нутагт ажиллах шуурхай бүлэгт дэмжлэг үзүүлж ажиллах;

4.2. Коронавирус илрүүлэх шинжилгээний хариуг euul.gerege.mn системд оруулахад гарч буй алдааг засах, мэргэжлийн баг гарган ажиллуулж шинжилгээ авахаас эхлэн хариу гарах хүртэлх үйл ажиллагааг журамлан зохицуулах;

4.3. Халдварын голомтыг тодорхойлох, хумих ажлын хүрээнд ойрын хавьтал, сэжигтэй тохиолдолд тавих хяналтыг сайжруулах, хавьтал тогтоох шинжилгээг нэмэгдүүлэх зэргээр тандалт судалгааны ажлыг эрчимжүүлэх;

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга Ц.Ганзориг нарт:

5.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, орон нутаг хооронд зорчихдоо хог, хаягдлаа ил задгай хаяхгүй байх, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахих талаар сэрэмжлүүлэг, мэдээлэл, зөвлөмжийг бүх сувгаар иргэд, олон нийтэд тогтмол хүргэх;

5.2. Дархлаажуулалтын бүрэн тунд иргэдийг хамруулах хугацаа /2021 оны 6 дугаар сарын дунд/ дуусах хүртэл 0-17 насны хүүхдүүдийг коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлж аль болох хот, орон нутаг хооронд авч зорчихгүй байх, эцэг, эх, асран хамгаалагчдын хүүхдэд тавих хараа хяналт, хариуцлагыг дээшлүүлэх талаар сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдээллийг боломжит бүх сувгаар иргэд, олон нийтэд тогтмол хүргэх;

Зургаа. Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын гишүүн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Б.Ганзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

6.1. Мал, амьтны гоц халдварт, зооноз өвчин гарах, хил дамжин халдварлахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах. Дархлаажуулалт, тандалт шинжилгээ, эрүүл мэндийн үзлэг хийх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангаж, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ